



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны

Аудитын код: ОРА-2025/021/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг:
ppurevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: "Төгс нотолгоо аудит" ХХК-ийн Ахлах аудитор:
Г.Цэцэгмаа
Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.09.21 № 27

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ДОЛОО ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ЭРДЭНЭТОГТОХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн ерөнхий боловсролын долоо дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 128 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөхөөр сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг 7 дугаар хавсралтаар баталж, албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 147,423.9 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

Аудитын гол асуудал

Боловсролын Ерөнхий газраас 202 оны 12 дугаар сарын 21-ны 01/6148 дугаар албан тоотгоор Аймгийн Засаг даргын тамгын газарт чиглэл хүргүүлсний дагуу ерөнхий сургуулиудад гал тогооны түрээслэгч аж ахуйн нэгжийн гэрээг дуусгавар болгож, сургуулийн хэмжээнд хоол үйлдвэрлэл үйлчилгээг үзүүлэх ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулсан байна.

Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоос 38,431.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, хүнсний түүхий эд материал, тоног төхөөрөмж, ажиллагсдын эрүүл ахуйн хувцас, аж ахуйн материалын зардалд нийт 38,431.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг тайлант онд үнэлээгүй байна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 470 хүүхдээр тооцсон боловч 765 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>491,727,349.24</u>	<u>659,857,332.39</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	342,340,584.00	489,764,501.26
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	342,340,584.00	489,764,501.26
3121	Төгрөг	342,340,584.00	489,764,501.26
31212	Монгол банкин дахь харилцах	342,340,584.00	489,764,501.26
33	АВЛАГА	1,996,773.68	1,618,979.90
335	Бусад авлага	1,618,979.90	1,618,979.90
3351	Байгууллагаас авах авлага	1,618,979.90	1,618,979.90
35	БАРАА МАТЕРИАЛ	147,389,991.56	168,473,851.23
351	Түүхий эд материал	66,198,590.68	78,071,611.68
35110	Тусгай зориулалттай материал	65,464,440.68	77,586,611.68
35130	Эм боох материал	734,150.00	485,000.00
354	Хангамжийн материал	81,191,400.88	90,402,239.55
35410	Бичиг хэргийн материал	6,742,511.00	3,807,312.50
35420	Аж ахуйн материал	3,269,268.00	3,115,838.00
35440	Түлш, шатах тослох материал	1,722,157.53	1,933,405.00
35460	Хүнсний материал	-	458,480.00
35470	Бусад хангамжийн материал	69,457,464.35	81,087,204.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,639,700,202.08</u>	<u>3,875,141,635.57</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>3,639,700,202.08</u>	<u>3,875,141,635.57</u>
392	Биет хөрөнгө	<u>3,239,387,701.89</u>	<u>3,476,061,635.57</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,834,505,507.88	3,168,066,341.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(297,911,236.44)	(359,057,505.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,000,000.00)	(40,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	442,967,865.50	533,441,582.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(104,225,508.36)	(190,470,143.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	279,381,613.64	296,686,420.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,918,106.06)	(98,355,389.42)
39209	Зам, гүүр байгууламж	180,175,786.33	180,175,786.33
39210	Хуримтлагдсан элэгдэл	(32,588,220.60)	(54,425,457.30)
393	Биет бус хөрөнгө	<u>400,312,500.19</u>	<u>399,080,000.00</u>
39301	Программ хангамж	8,662,784.00	8,662,784.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,630,283.81)	(6,862,784.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	397,280,000.00	397,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,131,427,551.32</u>	<u>4,534,998,967.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>874,270.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	874,270.00
413	Өглөг	-	874,270.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	874,270.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,131,427,551.32</u>	<u>4,534,124,697.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>4,131,427,551.32</u>	<u>4,534,124,697.96</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,493,834,578.34	1,493,834,578.34
51101	Өмч: - төрийн	1,493,834,578.34	1,493,834,578.34
512	Хуримтлагдсан үр дүн	<u>280,626,968.35</u>	<u>683,324,114.99</u>

51210	Өмнөх үеийн үр дүн	280,626,968.35	280,626,968.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	402,697,146.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,356,966,004.63	2,356,966,004.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,131,427,551.32	4,534,998,967.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,960,118,542.00	2,962,336,832.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,452,442.00	682,823,332.70
120	Нийтлэг татварын бус орлого	6,452,442.00	682,823,332.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,452,442.00	682,823,332.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,407,400.00	5,588,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,045,042.00	219,772,835.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		439,379,358.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		18,082,239.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,953,666,100.00	2,279,513,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,859,077,300.00	2,174,566,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,859,077,300.00	2,174,566,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,588,800.00	104,946,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,588,800.00	104,946,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,796,906,761.01	2,559,639,686.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,796,906,761.01	2,559,639,686.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,692,984,298.18	2,443,668,654.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,209,557,897.65	1,732,190,283.00
210101	Үндсэн цалин	858,572,285.65	1,126,122,836.00
210102	Нэмэгдэл	307,898,757.00	541,778,818.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,841,200.00	3,085,059.00
210104	Урамшуулал	39,245,655.00	61,203,570.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,312,045.39	210,326,771.89
210201	Тэтгэврийн даатгал	103,715,765.81	144,879,094.46
210202	Тэтгэмжийн даатгал	12,234,817.52	17,405,125.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,678,654.04	9,102,236.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,242,590.02	7,750,283.04
210205	Эрүүл мэндийн даатгал	22,440,218.00	31,190,032.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,747,337.17	64,241,358.19
210301	Гэрэл, цахилгаан	14,578,961.00	17,880,383.43
210302	Түлш, халаалт	35,088,512.61	34,064,332.65
210303	Цэвэр, бохир ус	12,079,863.56	12,296,642.11
2104	Хангамж, бараа материалын зардал	15,096,463.00	708,729.00
210408	Бараа материал акталсны зардал	7,932,495.00	708,729.00
2105	Нормативт зардал	13,874,000.00	44,453,700.00
210502	Хоол, хүнс	13,795,200.00	44,453,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,747,450.00	25,985,850.00
210604	Урсгал засвар	22,747,450.00	25,985,850.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,261,330.00	26,089,054.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,182,500.00	4,890,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,078,830.00	21,198,754.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,387,774.97	339,672,908.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,390,784.92	111,897,283.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,995,520.00	21,877,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	154,001,470.05	205,897,924.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,922,462.83	115,971,031.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,244,000.00	102,684,390.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	79,182,000.00	102,684,390.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,678,462.83	13,286,641.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,678,462.83	13,286,641.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	163,211,780.99	402,697,146.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	159,140,731.00	402,697,146.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,960,118,542.00	2,504,875,235.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,452,442.00	225,361,735.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,452,442.00	225,361,735.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,452,442.00	225,361,735.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,407,400.00	5,588,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,045,042.00	219,772,835.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,953,666,100.00	2,279,513,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,859,077,300.00	2,174,566,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,859,077,300.00	2,174,566,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,588,800.00	104,946,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,588,800.00	104,946,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,637,438,958.28	2,355,491,317.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,637,438,958.28	2,355,491,317.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,519,721,295.45	2,239,936,075.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,209,598,567.50	1,732,190,283.00
210101	Үндсэн цалин	866,754,568.04	1,126,122,836.00
210102	Нэмэгдэл	299,650,156.46	541,778,818.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,832,000.00	3,085,059.00
210104	Урамшуулал	39,361,843.00	61,203,570.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,510,424.78	209,948,978.11
210201	Тэтгэврийн даатгал	103,914,145.20	144,501,300.68
210202	Тэтгэмжийн даатгал	12,234,817.52	17,405,125.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,678,654.04	9,102,236.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,242,590.02	7,750,283.04
210205	Эрүүл мэндийн даатгал	22,440,218.00	31,190,032.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,747,337.17	64,241,358.19
210301	Гэрэл, цахилгаан	14,578,961.00	17,880,383.43

210302	Түлш, халаалт	35,088,512.61	34,064,332.65
210303	Цэвэр, бохир ус	12,079,863.56	12,296,642.11
2105	Нормативт зардал	-	44,453,700.00
210502	Хоол, хүнс	-	44,453,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,074,250.00	27,418,800.00
210604	Урсгал засвар	18,074,250.00	27,418,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,561,330.00	27,389,054.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,182,500.00	4,890,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,378,830.00	22,498,754.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,229,386.00	134,293,902.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,439,786.00	112,366,202.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,789,600.00	21,927,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,717,662.83	115,555,241.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	108,039,200.00	102,268,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,977,200.00	102,268,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,678,462.83	13,286,641.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,678,462.83	13,286,641.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	322,679,583.72	149,383,917.26
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	59,288,100.00	1,960,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,288,100.00	1,960,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,288,100.00	1,960,000.00
222001	Тоног төхөөрөмж	59,288,100.00	1,960,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(59,288,100.00)	(1,960,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	263,391,483.72	147,423,917.26
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		342,340,584.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	342,340,584.00	489,764,501.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	280,626,968.35	4,131,427,551.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	280,626,968.35	4,131,427,551.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			402,697,146.64	402,697,146.64
D09	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,493,834,578.34	2,356,966,004.63	683,324,114.99	4,534,124,697.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,852,455,200.00	2,357,451,317.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,852,455,200.00	2,355,491,317.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,750,186,000.00	2,239,936,075.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,014,716,600.00	1,732,190,283.00
210101	Үндсэн цалин	1,276,832,900.00	1,126,122,836.00
210102	Нэмэгдэл	720,316,800.00	541,778,818.00
210104	Урамшуулал	17,566,900.00	61,203,570.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	251,839,700.00	209,948,978.11
210201	Тэтгэврийн даатгал	171,250,900.00	144,501,300.68
210202	Тэтгэмжийн даатгал	20,147,200.00	17,405,125.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,073,600.00	9,102,236.64
210204	Ажилгүйдлийн даатгал	10,073,600.00	7,750,283.04
210205	Эрүүл мэндийн даатгал	40,294,400.00	31,190,032.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,528,000.00	64,241,358.19
210301	Гэрэл, цахилгаан	16,296,700.00	17,880,383.43
210302	Түлш, халаалт	48,058,800.00	34,064,332.65
210303	Цэвэр, бохир ус	13,172,500.00	12,296,642.11
2105	Нормативт зардал	56,953,700.00	44,453,700.00
210502	Хоол, хүнс	56,953,700.00	44,453,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,418,800.00	27,418,800.00
210604	Урсгал засвар	27,418,800.00	27,418,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,633,200.00	27,389,054.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,767,500.00	4,890,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	51,865,700.00	22,498,754.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,096,000.00	134,293,902.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	241,168,300.00	112,366,202.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,927,700.00	21,927,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,269,200.00	115,555,241.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,269,200.00	115,555,241.81
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	102,269,200.00	102,268,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,852,455,200.00	2,504,875,235.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,747,508,400.00	2,174,566,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,747,508,400.00	2,174,566,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	104,946,800.00	104,946,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	104,946,800.00	104,946,800.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 31,561.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 31,561.3 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар 10,816.0 мянган төгрөгийн авлага, 20,745.3 мянган төгрөгийн өглөгтэй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байсан алдааг залруулж тайлагнасан.

Аудитаар нийт 39,548.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 11,166.0 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 28,362.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 11,166.0 мянган төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт хүргүүлэв. Үүнд:

- Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч сургалтын менежер нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2,401.2 мянган төгрөгийн тусгай сургалтын нэмэгдэл хөлс авсан байна.
- Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/238 А/340 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад заагаагүй шинжилгээнд албан хаагчдыг хамруулж, 4,620.0 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан.
- Тайлант онд 4 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 638.0 мянган төгрөг илүү олгосон байна.
- Захирлын тушаалаар сахилгын шийтгэл хүлээсэн 2 албан хаагчид 1,324.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон
- Тайланд онд 2 албан хаагчид 1,005.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон
- Сургуулийн захиралд Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалыг үндэслэн 694.8 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон нийт 11,166.0 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 28,362.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн 1,544.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон.
- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,206.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн 1,544.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нийт 28,382.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах багшийн мэргэжил дээшлүүлэх, хүүхэд хамгаалах, хичээл практик, эрүүл мэндийг дэмжих, нөхөн хангалтын зардлыг зарцуулах ажлын хэсэг байгуулаагүй, хамт олноор хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл байхгүй төсвийг хяналтгүй үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зорилготой ажлуудыг ажлын хэсэг байгуулж, төсвийг үр ашигтай зарцуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ерөнхий боловсролын долоо дугаар сургууль	1	31.5			1	31.5	1	31.5				
Дүн	1	31.5			1	31.5	1	31.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ерөнхий боловсролын долоо дугаар сургууль	9	39.6	6	11.2	3	28.4	1	0				

